**МОНГОЛ УЛСЫН**
**ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН**
**ТУШААЛ**

2024 оны 02 сарын 08 өдөр Дугаар А/58 Улаанбаатар хот

Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд
мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх
зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8, 25.9.1 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/295 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох журам”-ын 4.5, 4.7 дахь заалт, Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн 2024 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл анх удаа олгох 5 гадаадын эмнэлгийн мэргэжилтний нэр, төрөлжсөн мэргэшлийн чиглэл, зөвшөөрлийн төрөл, хүчинтэй хугацааг нэгдүгээр, давтан олгох 2 гадаадын эмнэлгийн мэргэжилтний нэр, төрөлжсөн мэргэшлийн чиглэл, зөвшөөрлийн төрөл, хүчинтэй хугацааг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Зөвшөөрлийн гэрчилгээг баталгаажуулж олгохыг Эрүүл мэндийн хөгжлийн төв (Б.Нарантуяа)-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбарын хяналтын газар (С.Сүнчин)-т даалгасугай.

САЙД С.ЧИНЗОРИГ

14124032?

Эрүүл мэндийн сайдын 2024
оны 02 дугаар сарын 08 өдрийн
А/58 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

## МОНГОЛ УЛСАД МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ АНХ УДАА ОЛГОХ 5 ГАДААДЫН ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ НЭР, ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЧИГЛЭЛ, ЗӨВШӨӨРЛИЙН ТӨРӨЛ, ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА

| № | Овог нэр | Харьяалал | Монгол Улсад ажиллах эрүүл мэндийн байгууллага | Төрөлжсөн мэргэшлийн чиглэл | Зөвшөөрлийн төрөл | Зөвшөөрлийн хүчинтэй хугацаа |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Шах Дирен Шантилал | БНЭУ | Улсын гуравдугаар төв эмнэлэг | Зүрх, Цээжний хөндийн мэс засал судлал | Эмчлэх | 5 өдөр<br>2024.02.13-2024.02.17 |
| 2 | Чонг Нань Хы | БНСУ | Өргөө амаржих газар төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг | Эх барих, эмэгтэйчүүд судлал | Эмчлэх | 2 өдөр<br>2024.02.26-2024.02.27 |
| 3 | И Сонг Хүнь | БНСУ | Өргөө амаржих газар төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг | Эх барих, эмэгтэйчүүд судлал | Эмчлэх | 2 өдөр<br>2024.02.26-2024.02.27 |
| 4 | Бхансали Даршан | БНЭУ | Хавдар судлалын үндэсний төв | Хавдрын мэс засал судлал | Эмчлэх | 3 өдөр<br>2024.02.19-2024.02.21 |
| 5 | Ким Жун Шиг | БНСУ | Би Си Медикал ХХК-ийн Пи Ди Ай Си эмнэлэг | Нүүр ам судлал | Эмчлэх | 5 өдөр<br>2024.03.28-2024.04.01 |

Эрүүл мэндийн сайдын 2024
оны 02 дугаар сарын 08 өдрийн
А/58 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

МОНГОЛ УЛСАД МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ДАВТАН ОЛГОХ 2 ГАДААДЫН ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ НЭР, ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЧИГЛЭЛ, ЗӨВШӨӨРЛИЙН ТӨРӨЛ, ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА

| № | Овог нэр | Харьяалал | Монгол Улсад ажиллах эрүүл мэндийн байгууллага | Төрөлжсөн мэргэшлийн чиглэл | Зөвшөөрлийн төрөл | Зөвшөөрлийн хүчинтэй хугацаа |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Пунит Сингла | БНЭУ | Хавдар судлалын үндэсний төв | Хоол боловсруулах мэс засал судлал | Эмчлэх | 2 өдөр<br>2024.02.19-2024.02.20 |
| 2 | Риахи Сам | Дани | Улсын нэгдүгээр төв эмнэлэг | Зүрх судлал | Эмчлэх | 13 өдөр<br>2024.03.11-2024.03.23 |